

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ.
- (*) тэмдэгтэй даалгавруудыг хөгжим болон дуу сонссоны дараа гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн хариултаас зөвхөн нэг хариултыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

***Н.Жанцанноров “Цагаан суварга” бүтээлийг сонсоод 1-4 дүгээр даалгаврыг гүйцэтгээрэй.**

1. *Хөгжмийг анхааралтай сонсоод, зохиолын хурдыг тодорхойлно уу.

A. дунд зэрэг B. хурдан C. хурдавтар D. тайван

2. *Ноот бичлэгт байгаа  тэмдэг ямар үүрэгтэй вэ?



A. Амьсгаа авах B. Давтаж тоглох C. Зогсох D. Удаашрах

3. *Зохиолын утга санааг илэрхийлэхэд өгсөн зургуудаас аль нь тохирох вэ?



4. *Зохиолыг ямар ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдөж байна вэ?

A. Морин хуур, Ятга, Шанз, Гитар
B. Ёочин, Морин хуур, Лимбэ, бөмбөр
C. Ятга, Ёочин, Морин хуур, Лимбэ
D. Гитар, Морин хуур, Бөмбөр, Шанз

***Буриад ардын “Алтаргана” дууг сонсоод 5-8 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**

5. *Ноот бичлэгт байгаа  тэмдгийн үүргийг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоно уу.



A. Эгшгийг хагас өнгөөр дээшлүүлэх үүрэгтэй.
B. Эгшгийг хагас өнгөөр доошлуулах үүрэгтэй.
C. Эгшгүүдийг огцом тасалдангуй хөгжимдөх үүрэгтэй.
D. Эгшгүүдийг тасралтгүй үргэлжлүүлэн хөгжимдөх үүрэгтэй.

6. *Бүтээлд хөөмийн ямар төрлийг хэрэглэсэн байна вэ? Сонгоно уу.

A. Исгэрээ B. Хархираа C. Шахаа D. Амаар таших

7. * Буриад ардын “Алтаргана” бүтээлийг орчин үеийн ямар төрлөөр туурвисан байна бэ?
А. Фолк рок В. Этник С. Джаз D. Рок
8. * Дууны хурд ямар байна вэ? Тохирохыг сонгоорой.
А. хурдан В. удаан С. хурдавтар D. маш удаан
9. Монгол ардын уртын дууг дуулах аялгаар нь зөв ангилсан хувилбарыг сонгоно уу.
А. Боржигон, Бэсрэг, Төв халх, Суман
В. Бэсрэг, Айзам, Суман, Боржигон
С. Бэсрэг, Айзам, Боржигон, Төв халх
D. Төв халх, Баян бараат, Боржигон, Зүүн аймгийн
10. Хөгжмийн зэмсгүүдийг хөгжимдөх арга барилтай нь зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу.

1. 	а. Чавхдасыг тусгай цохиураар цохиж дуу авиа үүсгэдэг
2. 	б. Хуруугаар чимхэх буюу этэн товшиж эгшиглүүлдэг
3. 	в. Амны хөндий, хэл, шүдний тусламжтай эгшиглүүлдэг
4. 	г. Чавхдасыг нумаар хөрөөдөн тоглоно

- А. 1г 2в 3б 4а В. 1б 2г 3а 4в С. 1в 2г 3б 4а D. 1б 2г 3в 4а
11. Хөгжимт аман зохиолын төрлүүд аль нь вэ? Зөв хувилбарыг сонгоно уу.
А. Хөөмий, исгэрээ, цуур В. Монгол ардын богино дуу, уртын дуу
С. Ерөөл, магтаал, тууль D. Бий биелгээ
12. Зургаас монгол ардын дуулах урлагийг илэрхийлснийг сонгоорой.
А.  В.  С.  D. 
13. Намба төрх нь жавхаалаг, сэтгэлийн дотоод илэрхийллийг гарын хурц, тод таталт шидэлтээр гаргаж, тухайн ястны зан аалийг харуулдаг онцлогтой биелгээ аль вэ? Тохирохыг сонгоно уу.
А. Захчин В. Хотон С. Баяд D. Торгууд

14. Язгуур бий биелгээний гарын байрлалын зургийг нэршилтэй нь зөв харгалзуулсныг сонгоно уу.

1.



а. Дээдлэх гар

2.



б. Мэндийн гар

3.



в. Баярын гар

4.



г. Залбирлын гар

A. 1б 2г 3в 4а

B. 1а 2в 3б 4г

C. 1б 2в 3а 4г

D. 1а 2г 3в 4б